

# "ӨЛЗИЙДУНДГОВЬ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04-р сарын  
28-ны өдөр

№ 01

Мандалговь

Компанийн 2020 оны үйл ажиллагааны  
болон санхүүгийн тайланг батлах тухай.

Компанийн тухай хуулийн 69.1.9 дэхь заалт, компанийн санхүүд хийсэн аудит болон хувьцаа эзэмшигчдээс гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2020 оны тайлан тэнцлийн нийт хөрөнгийг 426686,7 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн хөрөнгийг элэгдэл хассанаар 324067,4 мянган төгрөгөөр, эргэлтийн хөрөнгийг 102619,3 мянган төгрөгөөр тус тус тооцож тайлан тэнцлийн дүнг баталсугай.

2. Компани 2020 онд 89441,5 мянган төгрөгийн орлого олж 119284,1 мянган төгрөгийн зардал гарган 29842,6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байх ТУЗ-ийн шийдвэрийг баталсугай.

3. Компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэх 2021-2023 оны бизнес төлөвлөгөөг баталсугай.

4. Хувьцаа эзэмшигчдээс гаргасан санал зөвөлгөөг үйл ажиллагаандаа тусган, хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилтуудаа ханган биелүүлэх талаар идэвхи санаачлага гарган ажиллахыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

Хурлын дарга



Н.Буянхүү

**“ӨЛЗИЙДУНДГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 4-р сарын  
28-ны өдөр

№ 02

Мандалговь

ТУЗ-ийн гишүүдийг батлах тухай.

Компанийн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар авсан саналын дүнг нэгтгэсэн тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ-ийн гишүүдээр Н.Цоож, Н.Буянхүү, Д.Мөнх-Очир, Г.Эрдэнэбаатар, Н.Баярсүрэн, Х.Төмөрсумъяа нарыг, хараат бус гишүүдээр Б.Ганбаяр, П.Аюусэд, Ц.Энхтуяа нарыг тус тус баталсугай

2. Компанийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлж ашиг орлогыг нэмэгдүүлэн хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа нэр төртэй биелүүлж ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

Хурлын дарга



Н.Буянхүү